



ДОРНОГОВЬ АЙМАГ  
ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 159

Гурван хөвсгөл

Газар эзэмшүүлэх төсөл сонгон  
шалгаруулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулан явуулах журам", сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 2026 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөнд тодотголоор тусгагдсан 1 нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр холбогдох хууль тогтоомжийн дагуу танхимын хэлбэрээр зохион байгуулахыг Хөвсгөл сумын Газрын даамлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн (О.Оюунцэцэг)-д үүрэг болгосугай

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Мөнх-Од)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




З.МӨНГӨНБАГАНА

C:\Users\user\Documents\2026 on\zahiramj tushaal-26\Zahiramj-26.docx

4412600149

Сумын Засаг даргын 2026 оны  
05 дугаар сарын 14-ний өдрийн  
159 дугаар захирамжийн хавсралт



· ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ЭЗЭМШҮҮЛЭХ  
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА

| № | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Эзэмшүүлэх газрын байршил          | Хэмжээ м.кв | Зориулалт                     | Эзэмшүүлэх хугацаа |
|---|-----------------------------------|------------------------------------|-------------|-------------------------------|--------------------|
| 1 | 2                                 | 3                                  | 4           | 5                             | 6                  |
| 1 | 5113664                           | 3-р баг, Бурхант уулын баруун талд | 50000       | 1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл | 15 жил             |

--- оОо ---

